| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,750,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,750,000.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,750,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,750,000.00 | |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,750,000.00)** | - |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (0.00) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 390,770,500.00 | 390,763,800.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 390,770,500.00 | 390,763,800.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 353,427,100.00 | 353,420,400.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 215,816,300.00 | 215,816,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 136,557,800.00 | 136,557,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,401,200.00 | 73,401,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,857,300.00 | 5,857,300.00 |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,165,200.00 | 26,165,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,412,500.00 | 18,412,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,938,200.00 | 1,938,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,550,500.00 | 1,550,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 387,700.00 | 387,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,876,300.00 | 3,876,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,660,700.00 | 15,660,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,513,000.00 | 1,513,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,991,700.00 | 13,991,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 156,000.00 | 156,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,000,900.00 | 12,000,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,882,600.00 | 3,882,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,070,200.00 | 7,070,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 841,100.00 | 841,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 207,000.00 | 207,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 591,100.00 | 591,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 591,100.00 | 591,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,734,400.00 | 7,734,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,883,300.00 | 3,883,300.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 202,200.00 | 202,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,648,900.00 | 3,648,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,958,700.00 | 4,958,700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,958,700.00 | 4,958,700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 66,199,800.00 | 66,193,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54,102,000.00 | 54,102,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 141,500.00 | 141,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 636,000.00 | 636,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 223,600.00 | 223,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,800,000.00 | 10,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 96,700.00 | 90,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,300,000.00 | 4,300,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,300,000.00 | 4,300,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,343,400.00 | 37,343,400.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,343,400.00 | 37,343,400.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 18,121,000.00 | 18,121,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,222,400.00 | 19,222,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 390,770,500.00 | 390,763,800.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 390,770,500.00 | 390,763,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 390,770,500.00 | 390,763,800.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 19.00 | 19.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **19.00** | **19.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11.00 | 11.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын тєрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8.00 | 8.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **3,500,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **3,500,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 3,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 1,300,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 1,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 2,200,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 3,500,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 3,500,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,000,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангахуйц бүс нутгийн болон хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн таатай орчныг бүрдүүлэх явдал юм.

Тус газрын алсын хараа нь дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай, байгалийн болон эдийн засгийн эрсдэл даах эрчимжсэн хөдөө аж ахуй, өндөр технологи бүхий хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарыг төлөвшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 537.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 501.2 сая төгрөгөөр буюу 1.7 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | | 7200.0 | 7200.0 |
| Бараа материал | 23651.8 | 25012.1 | 1360.3 |
| Үндсэн хөрөнгө | 160573.3 | 653225.6 | 492652.3 |
| **Нийт хөрөнгө** | **184225.1** | **685437.7** | **501212.6** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 184225.1 | 685437.7 | 501212.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **184225.1** | **685437.7** | **501212.6** |

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой авлага үүсгэж ажиллаагүй бөгөөд “Дата техниологи” компанид санхүүгийн программын үнэд шилжүүлсэн 10.8 сая төгрөгийн 7.6 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж, 3.2 сая төгрөгийг тайлант оны зардалд бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25.0 сая төгрөг болж 1.4 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон хандиваар ирсэн бараа материалын зарцуулаагүй үлдэгдэл нөлөөлжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй он удаан жил болсон бараа материалын байхгүй байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл бичиг хэргийн материал 2.0 сая төгрөгөөр, аж ахуйн материалын үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр өсөж, сэлбэг хэрэгслийн материал 0.5 сая төгрөгөөр, мал амьтад дансны үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр буурсан байна. ХХАА-аас 18.1 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй олгосныг дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 500.0 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 500.0 сая төгрөгийн дусаагүй барилгыг дансанд бүртгэсэнтэй холбоотой байна. Үндсэн хөрөнгөд нийт 7.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэнд үлдэгдэлгүй байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 501.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 501.2 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 420.5 сая төгрөгөөр буюу 86.0 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтийн орлого өмнөх оноос 35.8 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар буурч, тайлант онд хөрөнгө оруулалтаар баригдаж буй дуусаагүй барилгын үнэ 500.0 сая төгрөгийг, үнэ төлбөргүй хүлээж авсан 18.1 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн нь нийт орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 127.2 сая төгрөгөөр буюу 24.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын анхны төсвийг 340.7 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 390.8 сая төгрөг болгон өөрчилж анх баталсан төсвөөс 50.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.Энэ нь 57.5 сая төгрөгийн 3 хөтөлбөрийн төсвийг нэмж олгосонтой холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 23 арга хэмжээг санхүүжүүлэхээр 390.8 сая төгрөгийн төсөв баталснаас 390.8 сая төгрөгийг улсын төсвөөс, хүлээн авахаар төлөвлөсөн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 390.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 390.8 сая төгрөгийг зарцуулж, үндсэн санхүүжилтээс 0.01 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 390.8 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс 3.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 1.3 сая төгрөгийг, бараа үйлчилгээний зардалд 2.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 анхны төсвийг 340.7 сая төгрөгөөр баталж, тодотголоор 390.8 сая төгрөг болгон нэмэгдүүлж, 50.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Тодотгосон төсвөөр мал аж ахуйг хөгжүүлэх, газар тариаланг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөгжүүлэх, ажлын байр олгох зэрэг 3 хөтөлбөрт 57.5 сая төгрөгийг нэмэгдүүлэн, үйл ажиллагааны төсвийг анх баталснаас 7.5 сая төгрөгөөр бууруулсан байна.

Тодотгосон төсвөөр цалин, НДШ-ийн зардал болон тогтмол зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж зэрэг зардлуудыг хасаж тооцоход тэвчиж болох зардлын дүн 56.4 сая төгрөг ба хэмнэж болох 10 хувь 5.6 сая төгрөг байгаа нь анх баталсан төсвөөс тодотгож бууруулсан 7.5 сая төгрөгт багтаж байна гэж үзлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өгсөн чиглэлийн дагуу “Дата Ланд техниологи” компанид 10.8 сая төгрөгийн программын үнийг шилжүүлж, 7.6 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж, 3.2 сая төгрөгийг тайлант оны зардалд бүртгэсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 онд 107 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 390.7 сая төгрөгийн 85 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 178.5 сая төгрөгийн 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 80.0 сая төгрөгийн 3 гүйлгээг байршуулсан эсэхийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 71.4 хувьтай байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гүйцэтгэлийн аудитаар үзэх шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шилэн дансны 178.5 сая төгрөгийн 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, ажилчдад олгосон урамшуулалт цалинг холбогдох журмын дагуу тооцож олгоогүй зөрчил илэрч зөвлөмж өгөгдлөө.

**4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

**4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

**4.3 Албан шаардлага**

Байхгүй

**4.4 Зөвлөмж**

*1.Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал*

*1.1. Илрүүлэлт:*

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах ёстой мэдээллээс 178.5 сая төгрөгийн 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, Шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн хугацаанд байршуулах.

*1.2. Илрүүлэлт:*

Цалингийн сангаас 19.5 сая төгрөгийн урамшуулалт цалинг олгохдоо холбогдох журмын дагуу тооцож олгоогүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:*

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг мөрдлөг болгон ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | ХХАА-н газар | | | | | | | | | 2 | 198.0 |